



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 07 өдөр

Дугаар 11/94

Шивээговь сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4.3 дахь заалт, 31 дүгээр зүйлийн 31.2, 33 дугаар зүйлийн 33.1.1, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 07 дугаар “Сумын 2021 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2 дугаар баг, 21 дүгээр зөрлөгийн хойд талд байршилтай 35 га газрыг “Үйлдвэрлэл”-ийн зориулалтаар Шивээ-Овоо хувьцаат компанид 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Монгол Улсын Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хуулийг дагаж мөрдөхийг газар эзэмшигч Шивээ-Овоо хувьцаат компанийн гүйцэтгэх захирал /Ц.Энхтүвшин/-д үүрэг болгосугай.

3. Газар эзэмшигч Шивээ-Овоо хувьцаат компанийн гүйцэтгэх захирал /Ц.Энхтүвшин/-тэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамал /Э.Баярмагнай/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ